

Ерөнхийлөгч  
Диетер Ф.Угдорф  
Тэргүүн Зөвлөлийн  
хоёрдугаар зөвлөх



# Ариун Сүмийн адислалууд

Эцэг эх маань гэр бүлээ аван Европд анхных нь болох шинэхэн баригдсан Шведийн Ариун Сүм уруу мөнхийн гэр бүл болохоор явсныг би тод санаж байна. Тэгэхэд би 16-тай байсан бөгөөд дөрвөн хүүхдийн хамгийн бага нь байв. Бид хамтдаа тахилын ширээний өмнө өвдөг сөгдөн сууцгааж, дэлхий дээрх санваарын хүчээр үүрд мөнхөд холбогдох гайхамшигт амлалтаар лацдан холбогдсон юм. Би энэхүү сэтгэл догдлом агуу мөчийг хэзээ ч мартажгүй.

Гэр бүлээрээ лацдан холбогдохоор өөр улс орны хил даван явах нь бяцхан хөвгүүн надад гайхалтай санагдаж байв. Миний хувьд ариун сүмийн ажил нь дэлхийн хил хязгааруудыг гатлан, ертөнцийн бүх оршин суутчдад мөнхийн адислалуудыг авчрах бэлэг тэмдэг байв. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ариун сүмүүд нь яс үндэс, соёл иргэншил эсвээс улс төрийн байдлаас үл хамааран, үнэхээр бүх дэлхийн тусын тулд баригддаг билээ.

Ариун сүмүүд нь сайн сайхан ялах болно гэдгийн баттай гэрч юм. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Жорж К.Каннон (1827-1901) нэг удаа, “Ариун Сүмийн суурийн чулуу бүр, мөн баригдсан Ариун Сүм бүр дэлхий дээрх Сатаны хүчийг сааруулж, Бурханы болон Бурханлаг байдлын хүчийг өсгөдөг” гэжээ.<sup>1</sup>

Ариун сүм бүр дэлхий дээрх сайн сайхныг өсгөхөд нөлөөлдөг болохоор ариун сүмд ордог хүмүүст хамгийн агуу адислалууд ирэх нь лавтай юм. Тэнд бид гэрэл ба мэдлэгийг хүлээн авч, чухал гэрээнүүдийг хийдэг. Хэрэв бид тэдгээр гэрээнүүдийг дагах аваас Есүсийн шавь байх зам дээр алхахад маань тустай байх юм. Товчоор хэлэхэд, ариун сүм нь амьдралын нандин зорилго төдийгүй биеийн болон сүнслэг байдлаа үнэний дагуу авч явах арга замыг бидэнд заадаг.

Гэсэн ч бид зөвхөн өөрсдийнхөө төлөө ариун сүмд ордоггүй. Эдгээр нандин барилга байгууламжууд уруу орох бүрдээ бид Эцэгийн цорын ганц Хүүгийн цагаатгалын үр дүн болох Бурханы бүх хүүхдүүдэд боломжтой болгосон авралын ажилд өөрсдийн үүргүүдийг биелүүлдэг. Энэ бол аминч бус, ариун үйлчлэл бөгөөд мөнх бус байдалдаа Сионы уулан дээрх аврагчид болох агуу ажилд оролцох боломжийг бидэнд олгодог.

Ямар нэгэн шалтгаанаар одоохондоо ариун сүмд орж чадахгүй байгаа хүмүүст би ариун сүмийн зөвшөөрлийн бичгээ хадгалах хүчтэй байхын төлөө бүхнээ хийхийг урамшуулан дэмжиж байна. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг нь бидний итгэлтэй байдал ба Их Эзэнд үйлчлэх шийдвэр төгс байдлын маань

тэмдэг байх юм. Энэ бол Есүсийн “Миний тушаалуудыг сахьдаг хүн Намайг хайрлагч мөн. Намайг хайрлагч хүн Миний Эцэгт хайрлагдана. Би тэр хүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд илчилнэ” гэж заасан (Иохан 14:21), бидний Их Эзэнээ гэсэн хайрын тэмдэг мөн.

Дэлхий Их Эзэний адисалсан эдгээр нандин барилгуудаар ямагт үзэсгэлэнтэй сайхан болж, ариун сүмийн зөвшөөрлийн бичгээ хадгалан, ашиглахад зохистой байснаар бид тэнгэрийг дэлхийд ойртуулан авчрахын төлөө өөрсдөөсөө шалтгаалах бүхнийг хийх болно хэмээн би залбирч байна. Тийн байх аваас сайн сайхан зөвхөн бидний амьдрал, гэр оронд төдийгүй бидний амьдарч буй нийгэм хамт олон улмаар бүх дэлхий даяар гарцаагүй өсөн дэгжих болно.

#### ЭШЛЭЛ

1. Жорж К.Каннон, in “The Logan Temple,” *Millennial Star*, 1877 оны 11-р сарын 12, 743.

## ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Зааж буй санаагаа зөвхөн ярихын оронд үзүүлэн таниулах материал ашигласнаар ихэнх хүмүүс илүү сайн суралцаж, удаан хугацаанд тогтоож чаддаг (*Teaching, No Greater Call* [1999], 182-г үз). Хичээлийн турш ариун сүмийн зургийг үзүүлэхийг хичээ. Өгүүллийг уншсаныхаа дараа ариун сүм нь яагаад Ерөнхийлөгч Угдорфд чухал байсныг ярилц. Гэр бүлийн залуу хүүхдүүдийг гэр бүлээрээ ариун сүмд байгаа зураг зурахыг хүс.

*Teaching, No Greater Call* дээр “Өөрийн чинь зааж буй зарчмуудаар амьдрахад нь туслах нэг буюу хэд хэдэн зорилго тавихыг тэдгээр хүмүүсээс хүс” (159). Ерөнхийлөгч Угдорфын захиасыг гэр бүлээрээ унш. Мөн гэр бүлийн гишүүдийг ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхаар зохистой үлдэхэд туслах үүднээс хувийн зорилгоо бичихийг тэднээс хүс.

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

### Өндөр дээрээс харагдах үзэгдэл

Минди Райе Хомс

Бага байхдаа би Калифорнийн Сан Диего дахь Ариун сүмд олон нас барагсдын төлөөх баптисм гүйцэтгэх боломжтой байлаа. Хэдийгээр үргэлж сайхан дурсамжтай байдаг байсан ч нэг аялал маань сэтгэлд онцгойгоор үлдсэн юм.

Би 16 настай, дүү охин маань 12 хүрч, анх удаагаа нас барагсдын төлөөх баптисм хийхээр явж байлаа. Тэр анх удаа ариун сүмд ирж байгаа болохоор бид ёслолын дараагаар ариун сүмийн гадна талбайг тойрч үзэхээр шийдлээ.

Ариун сүмийн гаднах талбайн нэг талд алсыг харах хоёр өндөрлөгтэй бөгөөд бид тийш очлоо. Сан Диегогийн Ариун сүм нь хурдны замын ойролцоо байрладаг тул өндөрлөг дээрээс доош харахад хурдны зам харагддаг юм.

Тэр өдөр ариун сүмийн хамгийн өндөрлөг хэсэгт зогсож байхад амьдралын талаарх нэгэн үзэл бий болсон юм. Би доош хурдлах машинууд, түмэн олон шавсан худалдааны төвүүд болон элдэв зурагт хуудас тэмдгүүдээр дүүрэн хурдны замыг харж байв.

Энэ бүгдийг хараад толгойд минь: “Чи энэ бүгдийн нэг хэсэг байхыг хүсэхгүй байгаа биз дээ. Энэ бол чиний хүссэн амьдрал биш” гэсэн бодол орж ирсэн юм. Амьдралын зорилго бол Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болж, Түүн уруу эргэн очих гэдгийг би үргэлж заалгаж байсан билээ. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд надад дэлхийн зүйлс хэрэггүй гэдгийг би мэдэж байв.

Би үзэсгэлэнт ариун сүм уруу эргэн харлаа. Надад амьдралыг үзэх үзлийг өгсөн сайн мэдээний талаар мэдлэгтэй байгаадаа би баяртай байлаа. Дэлхийн хөл толгойгүй үймээн, өөрчлөлтийн дунд өндөрт зогсох газар надад байдаг гэдгийг би мэдэж байлаа.

Тэр өдөр ариун сүм дээр би дэлхийн талд биш үргэлж Түүний талд зогсох болно гэсэн амлалтыг Тэнгэрлэг Эцэгтээ амласан юм. Дэлхий бидний дээр юу ч тохиолдуулж байсан ч бид хийсэн гэрээнүүдээ сахиж, ариун газруудад зогссоноор тэдгээрийг даван туулж чадна (С ба Г 87:8).

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

### Дэлхийг илүү үзэсгэлэнтэй болгох нь

Ариун сүм барихад дэлхий дээр Бурханы Ахүч улам ихсэж, дэлхийг илүү үзэсгэлэнтэй болгодог гэж Ерөнхийлөгч Угдорф хэлсэн. Дараах зургийг буд. Ариун сүмээс хүмүүсийн хүртдэг гайхалтай адислалуудын зарим нь доор

байна. Нэгэн өдөр ариун сүмд орно гэж зохистой  
амьдарч байснаар эдгээр адислалууд та нарынх  
болж чадна!

Хайр ба үзэсгэлэн төгс газар

Амьд байхдаа хараахан баптисм хүртэж

амжаагүй хүмүүсийн төлөөх баптисм

Мөнхөд үргэлжлэх гэрлэлт

Хүүхдүүд эцэг эхтэйгээ мөнхөд лацдан холбогддог

Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн тухай суралцах газар

Зохистой, дуулгавартай амьдрал



# Итгэл болон хувийн зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүл

Энэ материалыг судлаад боломжтой бол айлчлан очих эгчтэй хамт үүнийг ярилцан хэлэлц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх, Нийгмийн Халамжийн Бүлгийг амьдралынхаа хэсэг болгоход нь туслах асуултуудыг ашигла.

Итгэл • Гэр бүл • Үйлчлэл

## Дараах судруудаас суралц:

Исаиа 2:2–3; С ба Г 109:22–23;  
110:8–10

## Ариун сүмд шүтэн бишрэх зохистой байх бидний үүрэг хариуцлага

"Ариун сүмд хүлээн авдаг гэрээ болон ёслолууд нь Бурханы оршихуйд очих зөвшөөрөл маань болдог. Эдгээр гэрээнүүд бидний хүч чадал, төлөв хүрэхээргүй их өндөрт биднийг өргөн хөгжүүлдэг. Бид хаант улсыг байгуулах өөрсдийн үнэнч, сүсэг бишрэлтэй байдлаа харуулан гэрээнүүдийг хийдэг. Бид Бурханы гэрээнд орж, Түүний гэрээт хүмүүс болдог. Эдгээр гэрээнүүдэд итгэлтэй байснаар бүх амлагдсан адислалууд нь биднийх болдог. . . .

"Сүмийн эмэгтэйчүүд ариун сүмийн адислалуудыг өөрийн болгохын тулд юу хийж чадах вэ?

"Түүний бошиглогчдоор дамжуулан Их Эзэн ариун сүмийн адислалуудыг хүлээн аваагүй хүмүүсийг урьж, тэдгээрийг хүлээн авахын тулд юу хийх хэрэгтэйг хэлдэг. Тэр эдгээр адислалуудыг хүлээн авсан хүмүүсийг олон дахин эргэн ирж, гайхамшигт баяр баясгаланг дахин дахин эдлэхийг, Түүний мөнхийн төлөвлөгөөний тухай өөрсдийн үзэгдэл ба ойлголтоо хөгжүүлэхийг урьдаг.

"Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхаар зохистой байцгаая. "Гэр бүлээ үүрд лацдан холбуулахын төлөө ариун сүмд явцгаая. Нөхцөл байдал боломж олгохын хэрээр ариун сүмд аль болох олон удаа очигцооё. Нас барсан төрөл төрөгсөдөө өргөмжлөлийн ёслолуудыг хүлээн авах боломжийг олгогцооё. Ариун сүмд тогтмол орсноор өөрсдийнхөө хүлээн авдаг сүнсний хүч чадлыг эзэмшиж, илчлэлт хүлээн авцгаая. Цагаатгалын бүрэн адислалыг хүлээн авахын тулд итгэлтэй байж, ариун сүмийн гэрээнүүдээ сахицгаая."<sup>1</sup>

*Сильвия Х.Оолред, Нийгмийн Халамжийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх.*

## Бидний түүхээс

Нийгмийн Халамжийн Бүлэг нь эгч нарын ариун сүмд шүтэн бишрэх хүслээс өсч хөгждөг гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910-2008) заасан.

"Көртландын Ариун сүмийн барилгын ажлын үеэр ариун сүмийн хананд ашигласан ханын шохойг жижиглэн нунтагласан шаазан эдлэлтэй хольж, нар, сарны гэрлийг ойлгож, барилгыг үзэсгэлэнтэй харагдуулах гялалзсан өнгөтэй болгох ажилд эмэгтэйчүүдийг дуудсан юм.

"Энэ ажлын үед хэдийгээр мөнгө бага байсан ч ажилчид агуу их итгэл, өөрсдийн хүч чармайлт, нөөц боломжоо Их Эзэний өргөө болох барилгын ажилд зориулсан юм. Эмэгтэйчүүд тэднийг өөрсдийн хийж чадах хамгийн амттай хоол хүнсээр хангаж байлаа. Эдвард В.Таллиж эмэгтэйчүүд ариун сүмийн хөшгийг оёж байхад Иосеф Смит тэднийг хараад 'Эгч нар аа, та нар үргэлж бэлэн байх юм даа. Эгч нар бүх сайн ажлын үргэлж эхэнд бөгөөд тэргүүн эгнээнд нь явдаг. Мари амилалтын эхэнд байсан, одоогийн эгч нар ариун сүмийн доторх ажлын эхэнд нь байна гэснийг тэмдэглэсэн байдаг.' . . .

"Мөн Наувуугийн ариун сүмийн барилгын ажилд ажилчдын цамц хийхээр цөөхөн хэдэн эгч нар хамтдаа цугларсан. Эдгээр нөхцөл байдлуудын үр дүнд 1842 оны гуравдугаар сарын 17-ны Пүрэв гарагт Бошиглогчийн агуулахын дээд өрөөнд арван хоёр эгч хамтдаа цугларсан байв."<sup>2</sup> Ингэж Нийгмийн Халамжийн Бүлэг эхэллээ тавьсан билээ.

## Эшлэл

1. Сильвия Х.Оолред, "Ариун Сүмүүд, нандин гэрээнүүд" *Лиакхона*, 2008 оны арваннэгдүгээр сар, 113, 114.
2. Гордон Б.Хинкли, "Ambitious to Do Good," *Ensign*, 1992 оны гуравдугаар сар, 2.

***Бид юу хийж чадах вэ?***

**1.** Би эгч нарыг ариун сүмд ороход, бэтгэхэд нь туслах ямар тус дэмийг өгч чадах вэ?

**2.** Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахын төлөө золиослолыг хийсэн эртний эгч нараас өвлөн авсан үлгэр жишээг би хэрхэн үзүүлэх вэ?

**3.** Ариун сүмийн адислалуудыг би хэрхэн авах вэ?

НЭМЭЛТ мэдээллийг  
[www.reliefsociety.lds.org](http://www.reliefsociety.lds.org)  
дээрээс авна уу.